



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2024 оны 2 сарын 20 өдөр

Дугаар А/8

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1.Монгол Улс дахь Оросын Холбооны Улсын өмчийн маргаантай Дархан-Уул аймаг дахь газар, үл хөдлөх хөрөнгийн талаар үзлэг хийж, дүгнэлт гаргах үүрэг бүхий Ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

Д.Нарангэрэл

Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтсийн дарга

Гишүүд:

Б.Ариунболд

Улсын бүртгэлийн ерөнхий газрын Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газрын дарга /зөвшилцсөнөөр/

М.Баярмаа


Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтсийн мэргэжилтэн

2.Албан томилолтын зардлын төсвийг нэгдүгээр хавсралтад заасны дагуу холбогдох эх үүсвэрээс гаргаж зарцуулахыг Ерөнхий нягтлан бодогч (Д.Отгонтуяа), холбогдох байгууллагын санхүүд зөвшөөрсүгэй.

3.Ажлын хэсгийн удирдамжийг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

4.Удирдамжийн дагуу үзлэг шалгалтыг 2024 оны 03 дугаар сарын 04-ний өдрөөс эхлэн ажлын 5 хоногт багтаан хийж гүйцэтгэн, тайланг танилцуулахыг Ажлын хэсэг (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА



Б.ЦЭНГЭЛ

132013859


Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын даргын
 2024 оны 2 сарын 20-ны өдрийн дугаар тушаалын
 нэгдүгээр хавсралт

ОРОН НУТАГТ ТОМИЛОЛТООР АЖИЛЛАХ АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН, ЗАРДЛЫН ТӨСӨВ

(төгрөгөөр)

Д/д	Аймгийн нэр	Ажлын хэсэг		Ажиллах хүний тоо	Ажиллах хоног /кален дарь/	Томилолтын зардал	Замын зардал /шатахуун/	Нийт зардал
		Нэр	Албан тушаал					
	Дархан, Орхон, Дорнод							
1	Дархан-Уул	Д.Нарангэрэл М.Баярмаа П.Батдорж	ТӨБАХ-ийн дарга, мэргэжилтэн, жолооч	3	2	852,000.00	335,700.00	1,187,700.00
	ДҮН					852,000.00	335,700.00	1,187,700.00

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2024 оны 2 дугаар сарын 10 өдрийн
1/8 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт



АЖЛЫН ХЭСГИЙН АЖИЛЛАХ УДИРДАМЖ

Оросын Холбооны Улсын маргаантай өмчийн газар талбайн хамтарсан үзлэг шалгалтыг зохион байгуулах, үл хөдлөх хөрөнгийн акт гаргах үүрэг бүхий ажлын хэсэг дараах ажлыг хийж гүйцэтгэнэ.

1. Дархан-Уул аймагт дахь ОХУ-ын ашиглалтад байгаа (СОТ-1 конторын барилга, Зарубежстрой, СОТ-1 Зарубежстрой 2ш орон сууцны барилга) газар түүний дээрх үл хөдлөх хөрөнгийн цогцолборын бодит байдалд үзлэг, тооллого, хэмжилт хийж, акт үйлдэж баталгаажуулна. /фото зураг, видео бичлэг хийх, маягт мэдээлэл бэлтгэх/

2. Үл хөдлөх хөрөнгийн чанар байдал, улсын бүртгэлд бүртгүүлэхэд шаардагдах баримт материалын бүрдлийг хангана.

3. Үзлэг, тооллого, хэмжилтийн дүнгээр тайланг бэлтгэж акт үйлдэн хамтарсан Ажлын хэсгийн хуралдаанд танилцуулахад бэлтгэнэ.

-----000-----